



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 66

Номгон

Баянхонгор Нью майнинг ХХК-ийг  
Корунд Гео ХХК-ний 20 хувийн хувьцаа  
эзэмшигчээр тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар 16.2, 62 дугаар зүйлийн 62.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 50 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Корунд Гео ХХК, Баянхонгор Нью майнинг орон нутгийн өмчит ХХК-ний хооронд байгуулсан гэрээний дагуу Корунд Гео ХХК-ний 20 хувийн хувьцааг үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбогдуулан Баянхонгор Нью майнинг ХХК-ийг хувьцаа эзэмшигчээр тогтоосугай.

2. Тогтоолыг хэрэгжүүлж холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Баянхонгор Нью майнинг орон нутгийн өмчит ХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Д.Мөнхсайхан/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

0117011